



*Сэдэв:*

*С.Эрдэнэ*

*“Өнчин янзага”*

*өгүүлэлэг*

# *Зорилго:*

**Эх зохиолд дүр болон  
уран сайхны задлал  
хийх тайлбарлах**

# *Зорилт:*

- **Зохиолын агуулгыг ярилцах**
- **Байгалийн зураглалт хэсгүүдийг олж тодорхойлох**
- **Байгалийн зураглал гэж юу вэ?**
- **Молом өвгөнд дүрийн хөрөг задлал хийх**
- **Хөрөг дүр гэж юу вэ?**
- **Ямар сэдвийг хөндсөн зохиол вэ?**
- **Барс янзага хоёрын нөхөрлөлийн талаар ярилцах**

# *Зохиолын агуулга:*



- Барс нохой Молом өвгөн хоёр ямар холбоотой вэ?
- Олон жилийн өмнө Барс ,Молом өвгөн хоёрт юу тохиолдсон бэ?



*Зургийг ажиглаад зохиолынхоо  
агуулгыг ярицъя.*



# *Өнчин янзагын хувь заяа*



# *Янзага Барс хоёр хэрхэн нөхөрлөв*





*Байгалийн зураглалт хэсгийг  
зохиолоос олж тайлбарлана уу.*






# *Байгалийн зураглалт хэсэг*

Манай Хэнтий уулын ой хөвч шиг сайхан орон байхгүй. Хадан цохионы нь **хаг хүртэл хивс торго шиг өнгөтэй** харагддаг, ой мод, цэцэг навч, **зөөлөн ногоон хөвд, сэрүүн тунгалаг ус булаг** нь хичнээн сайхан байдгийг та нар **хожим мэдэх болно доо.**

# *Байгалийн зураглал гэж юу вэ?*

Зохиолд уран сайхны тодорхой  
зорилгоор дүрсэлж буй  
байгалийн байдлын дүрслэл  
хэсгүүдийг хэлнэ.

# Дүрийн зураглал хийх тухай:





# Хөрөг дүр:



- Молом өвгөний дүрийг:  
А. Гадаад талаас нь  
Б. Дотоод талаас нь  
тоочиж бичнэ үү.

# *Молом өвгөний хөрөг дүр:*

## **• Гадаад төрх:**

**Тамхины утаанд шарсан сахал**

**Жартгар нүд**

**Судас шөрмөс нь гүрийсэн баргил том гар**

**Гурын арьсан бойтогтой**

# *Молом өвгөний хөрөг дүр:*

- **Дотоод зан чанар:**

**Нүдний хараа хурц**

**Өрөвч сайхан сэтгэлтэй**

**Амьтны дотоод сэтгэлийг ойлгодог**

**Байгаль дэлхийгээ хайрладаг**

**Хүүхдүүдэд ачлалтай.**



# *Хөрөг дүр гэж юу вэ?*

- **Зохиолын баатрын зүс царай, байр байдал, хэлбэр галбир, хувцас зүүсгэл, намба төрх, үйлдэл хөдөлгөөн өвөрмөц зан чанар гэх мэт онцлогийг нарийн уран сайхнаар, зураглан бүтээсэн хэсгүүдийг хөрөг дүр гэнэ.**

*Зохиолын сэдэв:*

**Ямар сэдвийг хөндсөн  
зохиол вэ?**

# Сэдэв: “Нөхөрлөл”



- ✓ Барс янзага хоёрын нөхөрлөлийн талаар
- ✓ Молом өвгөн, Барс нохой хоёрын нөхөрлөлийн талаар ярилцана уу.



# *Бүтээлч даалгавар*

Барс нохойны залуу ,хөгшин  
хоёр үеийн дүр төрхийг  
харьцуулан дэвтэртээ эх  
зохион бичиж хэрэглээрэй.

# *Гэрийн даалгавар*

Гурван сурагч нийлж  
зохиолын аль нэгээр дүр  
бүтээж жүжиглэн тоглоход  
бэлтгэж ирээрэй.

# *Зорилт:*

- **Зохиолын агуулгыг ярилцах**
- **Байгалийн зураглалт хэсгүүдийг олж тодорхойлох**
- **Байгалийн зураглал гэж юу вэ?**
- **Молом өвгөнд дүрийн хөрөг задлал хийх**
- **Хөрөг дүр гэж юу вэ?**
- **Ямар сэдвийг хөндсөн зохиол вэ?**
- **Барс янзага хоёрын нөхөрлөлийн талаар ярилцах**